

2025 оны 06 сарын 12 өдөр

№ BR 25/015

Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл
хийхийг зөвшөөрөх тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйл, 92 дугаар зүйлийн 92.1, Компанийн дүрмийн 7.4.17 заалт болон 2025 оны 06 сарын 12-ны өдрийн “Тэнгэр Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн ТУЗ-ийн ээлжит бус хурлын сонирхлын зөрчилгүй гишүүдийн шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Тэнгэр Даатгал” ХК-ийн Нийт хөрөнгийн 10 хүртэлх хувиар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан сонирхлын зөрчилтэй этгээдтэй болон түүнтэй холбогдох үнэт цаастай холбоотой хэлцлүүдийг байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Баянмөнх)-д олгосугай.
3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан эсэх талаарх тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд жил бүр тайлагнаж байхыг Гүйцэтгэх захирал (Б.Баянмөнх)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (А.Даваадорж)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.ГАНТУЯА